

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилго-1: Монгол улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.6, 2.2.7, 2.2.8 дахь заалт, Монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, 2.3.2 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1 дэх заалт, нийслэлийг 2021 -2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, Хан-уул дүүргийн засаг даргын 2024 -2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд							
НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД							
ЗОРИЛТ 1.1 МОНГОЛ УЛСЫН УРТ БОЛОН ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ЗАХИРАМЖ, ТУШААЛ, ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ							
1.1.1	Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам, НЗДТГ, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирсэн захирамж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Төсөв шаардахгүй	Захирамж, тушаал, шийдвэрийн биелэлтийн хувь	100	100	2025 оны байдлаар Эрүүл мэндийн төвд дээд газраас ирсэн тушаал, захирамж, албан даалгавар, зөвлөмж нийт 57 албан бичиг ирсэн бөгөөд тухай бүр биелэлтийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын албан даалгавар-3 Эрүүл мэндийн сайдын тушаал-8 Нийслэлийн засаг даргын тамгын газрын улсын байцаагчийн зөвлөмж-1 Нийслэлийн засаг даргын захирамж-8 Нийслэлийн эрүүл мэндийн газрын албан даалгавар-1 Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал-17 Хан-Уул дүүргийн засаг даргын захирамж-16 Хан-Уул дүүргийн онцгой комиссын тушаал, албан даалгавар-3 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зөвлөмж-1 тус тус ирсэн байна.	100%
1.1.2	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 тушаалаар баталсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжилтийг ханган ажиллах	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	93	95	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар баталсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж 2025 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт 96 хувьтай байна. Шинэ болон дахин сэргэж байгаа халдварын шуурхай удирдлагын багийг идэвхжүүлэн ажиллаж байна. Сүрьеэ, Бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэлтийг нэмэгдүүлэн ажиллаж байна.	100%
1.1.3	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар байгууллагын дунд хугацааны “Стратеги	Төсөв шаардахгүй	Батлуулсан стратеги төлөвлөгөөний тоо	-	1	Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвийн Стратеги төлөвлөгөөг /2025-2028 он/ боловсруулж 2025 оны 06 дугаар сард Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хэлтэс, дарга нараас санал тусгасан боловч Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дунд	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
	төлөвлөгөөг /2025-2028 он/ боловсруулан, батлуулах үйл ажиллагааг зохион байгуулна					хугацааны Стратеги төлөвлөгөө батлагдаагүй, үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай байгаа тул хойшлогдсон байна.	
ЗОРИЛТ 1.2. ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ХАЛДВАРТ БУС ӨВЧИН ЭМГЭГ, ТЭДГЭЭРИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТАНДАХ , УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ, ЭМЧЛЭХ ЗАМААР НАС БАРАЛТЫН ХУВИЙГ БУУРУУЛНА. /МУЗГ-2.3.1 ДЭХ ЗААЛТ, НЗДҮАХ-2.1 ДЭХ ХЭСЭГ, ДЗДҮАХ-2024-2028 ОН/							
1.2.1	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний (Хөх, умайн хүзүү, ходоод улаан хоолойн болон бүдүүн шулуун гэдэс, элэг, уушигны хорт хавдар, ЧШ, АГ ихсэх өвчин) - эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Хэрэгжилтийн хувь	АД-78% ЧШ-83% ХӨХ-78% УХ-44% ЭХ-35%	АД-80% ЧШ-83% ХӨХ-78.5% УХ-58%	2025 оны эхний 11 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэгт 162891 иргэн хамрагдахаас 113337 хамрагдаж, 70%-тай, 465 тохиолдол батлагдсан. 2024 оны мөн үед 123272 иргэн хамрагдаж, 80 хувьтай хамрагдсан бөгөөд өмнөх оноос 9935 үзлэгээр буюу 10 хувиар буурсан Чихрийн шижингийн эрт илрүүлэгт 108192 иргэн хамрагдахаас 91905 хамрагдаж, 85%-тай, 137 тохиолдол батлагдсан. 2024 оны мөн үед 34143 иргэн хамрагдаж 89 хувьтай байна. Мөн өмнөх оноос 57762 эрт илрүүлэгийн үзлэгээр нэмэгдсэн ч 4 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Хан-Уул дүүргийн нийт иргэн амын тоо өмнөх оноос 19 676 иргэнээр, өөрөөр хэлбэл 5.8 хувиар өссөнтэй холбоотой. Умайн хүзүүний хорд хавдрын эрт илрүүлэгт хамрагдвал зохих 15547 эмэгтэйчүүдээс эхний 4 сард хамрагдсан 12222 эмэгтэй 79%-тай байна. 2024 онд хамрагдсан иргэд 6818 байсан бол 2025 онд хамрагдсан эмэгтэйчүүд 5404 үзлэгээр нэмэгдсэн бол хөхний эрт илрүүлэг үзлэгт оношилгоонд хамрагдвал зохих 60677 эмэгтэйчүүдээс хамрагдсан 52940 эмэгтэй эрт илрүүлгийн хувь 87%-тай байна . 2024 онд эрт илрүүлэгт 42665 хамрагдаж байсан бол 2025 оны эхний 10 сарын байдлаар 10275 үзлэгээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100%
1.2.2	БЗДХ-ийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна	Улс, нийслэл, дүүргийн төсөв	10000 иргэн амд ноогдох илрүүлэлт /промиль/ Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь	2.3 38.6	2.4 43.6	2025 оны жилийн эцсийн байдлаар бэлгийн замаар дамжих халдварын тусламж, үйлчилгээнд нийт 24,190 иргэн хамрагдсан. Амбулаторийн үзлэг 7009, Идэвхтэй тандалтын үзлэг 2887, Жирэмсний хяналт 3211, Эрт илрүүлэг 3741, Эрсдэлт бүлэг 584, Гадаад иргэний урьдчилсан сэргийлэх үзлэг 1790, Урьдчилан сэргийлэх хуудас (гэрлэлт, гадаад явах, ажилд орох)-ийн үзлэг 4948 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Бэлгийн замаар дамжих халдварын шинээр бүртгэгдсэн нийт 149 тохиолдол илэрснээс тэмбүүгийн халдвар - 85, заг хүйтэн - 55, трихомониаз -9 илэрч нийт шинээр илэрсэн тохиолдлуудыг хяналтанд авч, эмчилгээний амжилт 97,9%, хавьтал илрүүлэлт 56% байна. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд бэлгийн замаар дамжих халдвар нийт 22 бүртгэгдсэнээс тэмбүүгийн халдвар 17,	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
						заг хүйтний халдвар 2, трихомониазын халдвар 3 илэрч жирэмсэн эмэгтэйчүүд хавьталын хамт хяналтанд орж бүрэн эмчлэгдсэн. 10,000 иргэн амд ноогдох илрүүлэлт 4,6 промилль байна. 2025 онд Хан-Уул засаг даргын тамгын газар, Хан-Уул дүүргийн цагдаагийн I, II хэлтэс, Улаан загалмай, Өлзийт асар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 831, Цэргийн штабтай хамтран зорилтот бүлэг буюу цэргийн насны 1162, Монголын өрхийн анагаах ухааны холбоотой хамтран хөдөлмөрийн насны сүрьеэгийн эрсдэлт бүлгийн 1654, нийт 3647 иргэнийг Бэлгийн замаар дамжих халдварын тусламж үйлчилгээнд хамруулсанаас шинэ халдварын 29 тохиолдол илэрч эмчилгээний хувь 95.8% байна.	
1.2.3	Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад иргэдийн мэдлэг, хандлагыг сайжруулахад чиглэсэн сурталчилгаа, мэдээллийг цахимаар хэлбэрээр иргэдэд түгээх ажлыг зохион байгуулах	0.5 сая	Хандалт авсан иргэдийн тоо	110,000	118,000	https://www.facebook.com/health.promotion.center цахим хуудсаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс болон Нийслэлийн эрүүл мэндийн газраас бэлтгэн гаргасан 25 төрлийн зурагт хуудсыг байршуулж 120790 хандалт авсан байна. https://www.facebook.com/khuemt.hospital цахим хуудсанд: - Эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн багийн эмч нар хиймэл оюун ухаанд суурилсан AI технологи ашиглан Умайн хзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг эсийн шинжилгээ - Хан-Уул дүүргийн “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээн - <u>Угаарын хийн эрсдэлээс сэргийлье</u> - Ахмадын эрүүл мэндийг дэмжих - Өсвөр үеийн өсөлт хөгжлийн үнэлгээ сэдэвт богино хэмжээний бичлэг бэлтгэн цацсан байна. нийт хандалтын тоо 210.000	100%
1.2.4	Өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжил арга зүйгээр хангах, дэмжлэг хяналтыг хэрэгжүүлж ажиллана	Төсөв шаардахгүй	Зохион байгуулсан дэмжлэг хяналтын тоо	5	6	Өрхийн эрүүл мэндийн төвийн 6 удаа дэмжлэгт хяналт хийж ажилласан. 1. 2024 оны 04 дүгээр сард ӨЭМТ-үүдэд Улаанбурхан өвчний бэлэн байдал, дархлаажуулалтын дэмжлэгт хяналт хийхэд дундаж үнэлгээ -76,3% байна. 2. 2025 оны 05 дугаар сард Чанарын алба, сувилахуйн алба, халдварын сэргийлэлтийн алба, нар хамтран ӨЭМТ-ийн яаралтай тусламжийн бэлэн байдал, улаанбурханы дархлаажуулалт сувилахуйн тусламж үйлчилгээний байдалд хяналт үнэлгээ хийж байна.	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
						3. 2025 оны 05 дугаар сард өрхийн менежер, лабораторийн эмч нар хамтран 4,5-р бүлгийн иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээ болон лабораторийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт үнэлгээ хийж байна.	
1.2.5	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийн богино болон урт хугацааны эрүүлжилтийн хувь нэмэгдүүлэх	Улс, нийслэл, дүүргийн төсөв	1,2-р ээлжний богино хугацааны эрүүлжилтийн хувь	17	18	Дүүргийн хэмжээнд 2024 оны 10-р сарын ээлжит цэрэг татлагаар орвол зохих 3578 цэргийн насны залуучуудаас 2199/62%/ нь заасан хугацаандаа ирж үзлэгт хамрагдсанаас 504 /23%/ цэргийн насны залуучууд өвчтэй илэрсэн .Өвчтэй илэрсэн залуучуудаас , дотрын өвчнөөр 136 буюу 27 хувийг эзэлж байна. Өвчтэй илэрсэн цэргийн үүрэгтний нэрсийг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт цахим хуудсаар дамжуулан хүлээлгэн өгч, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган 90%-ийг нь хяналтанд авч ажилласнаас 61нь буюу 12% нь 2024 оны 9 сараас 2025 оны 4 сарын хооронд эрүүлжүүлсэн байна. Өвчний ангилалаар нь авч үзвэл:1. Дотрын өвчнөөр-10%, Мэс засал-3%, 3.Гэмтэл-19%. 4. ДОХ/БЗДХ-67%.5.Чих хамар хоолой-20% 6. Сүрьеэ-20% 7. Биеийн жин-30%, 8. Шүд-100%.%, тус тус эрүүлжүүлсэн байна. - 2025 оны 5-р сарын ээлжит цэрэг татлагаар орвол зохих 3301 цэргийн насны залуучуудаас 3003 /91%/ нь заасан хугацаандаа ирж үзлэгт хамрагдсанаас 514 /17%/ цэргийн насны залуучууд өвчтэй илэрлээ. Өвчтэй илэрсэн 514 залуучуудаас дотрын өвчнөөр 159 буюу 31 хувийг эзэлж байна. Өвчтэй илэрсэн цэргийн үүрэгтний нэрсийг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт цахим хуудсаар дамжуулан хүлээлгэн өгч, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган 90%-ийг нь хяналтанд авч ажиллаз байна. Хан-Уул дүүргийн 2025 оны 2-р ээлжийн цэрэг татлагаар Засгийн Газрын 140, нэмэлт өөрчлөлт оруулсан 441-р тогтоолын журмыг мөрдөн Цэрэг татлагаар орвол зохих 3562 цэргийн насны залуучуудаас 3351 /94%/ нь заасан хугацаандаа ирж үзлэгт хамрагдсанаас 550 буюу 16 % нь өвчтэй илэрлээ. Өвчтэй илэрсэн 550 залуучуудаас дотрын өвчнөөр 238 буюу 43 хувийг эзэлж байна. Өвчтэй илэрсэн цэргийн үүрэгтний нэрсийг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт цахим хуудсаар дамжуулан хүлээлгэн өгсөн.	95%

ЗОРИЛТ 1.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАНДАХ, ЭМЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАН ӨВЧЛӨЛИЙГ БУУРУУЛНА. /НЗДҮАХ-2.1 ДЭХ ХЭСЭГ, ДЗДҮАХ-Н 2024-2028 ОН/

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1.3.1	Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн иргэн амын дунд болон хавьтлуудын дунд идэвхтэй эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж эмчилгээнд хамрагдалт, амжилтын хувийг нэмэгдүүлнэ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Хамрагдалтын хувь	20.3	21	2025 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд сүрьеэгээр өвдөх эрсдэлтэй иргэдийн судалгааг хороо тус бүрээр гарган 5688 иргэний судалгааг нэгтгэсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар Халдварт өвчин судлалын үндэсний төв, Глобал сан, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, Монголын өрхийн анагаах ухааны холбоо, Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэг, Өлзийт асар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран эрсдэлт бүлэгт багтах 4230 иргэнийг үзлэгт хамруулж нян судлалаар батлагдсан 17 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна. Мөн эрүүл иргэн амд чиглэсэн сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт Ерөнхий боловсролын 114, 10, 75, 52, 18 дугаар сургуулиудын ахлах ангийн нийт 2391 хүүхэд хамрагдлаж нян судлалаар батлагдсан 2 тохиолдол илэрсэн, цэргийн насны залуусын дунд хийгдсэн үзлэгт нийт 1228 иргэн хамрагдаж, нян судлалаар батлагдсан 1 тохиолдол тус тус илэрсэн байна. Сүрьеэгийн илрүүлэлтийн хамрагдалтын хувь 76.2% Жилийн эцсийн байдлаар эмчилгээний амжилт 79.8% байна.	100%
1.3.2	Эрсдэлт бүлгийн иргэдийн дунд бэлгийн замаар дамжих халдварын идэвхтэй илрүүлэлтийн хувийг нэмэгдүүлнэ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Идэвхтэй тандалтын илрүүлэлтийн хувь	30	35	2025 онд Хан-Уул засаг даргын тамгын газар, Хан-Уул дүүргийн цагдаагийн I, II хэлтэс, Улаан загалмай, Өлзийт асар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 831, Цэргийн штабтай хамтран зорилтот бүлэг буюу цэргийн насны 1162, Монголын өрхийн анагаах ухааны холбоотой хамтран хөдөлмөрийн насны сүрьеэгийн эрсдэлт бүлгийн 1654, нийт 3647 иргэнийг Бэлгийн замаар дамжих халдварын тусламж үйлчилгээнд хамруулсанаас шинэ халдварын 29 тохиолдол илэрч эмчилгээний хувь 95.8% байна.	100%
1.3.3	Томуугийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, томуугийн тархалтын түвшингийн үе шат бүр тохирсон хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Томуугийн тандалтын тогтолцооны төлөвлөгөөний хувь.	92	100	ЭМС-ын 2022 оны “Журам, заавар батлах” А/373, НЗД-ын 2023 оны 9 сарын 14-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/1070 дугаар захирамж, НЭМГ-ын даргын 2024 оны 10 сарын 31-ний “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” А/165 тушаалыг үндэслэн “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед 2024-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон хариу арга хэмжээний төлөвлөгөөг 3 чиглэл, 56 ажлыг төлөвлөн ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувьтай байна.	98%

ЗОРИЛТ 1.4 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД БОЛОВСРОЛ ОЛГОХ, ИРГЭДЭД ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ, ЗӨВ ДАДЛЫГ ХЭВШҮҮЛЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД /МУЗГ- 2.3.1 ДЭХ ЗААЛТ, НЗДҮАХ 2.1 ДЭХ ХЭСЭГ, ДЗДҮАХ-Н 2024-2028 ОН/

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1.4.1	Олон нийтийн цахим сүлжээ, цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэх урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг Хан-Уул ЭМТ-н цахим, Веб, page хуудас, Дүүргийн шуурхай штабын page хуудсаар мэдээллийг иргэдэд түгээж ажиллана	Төсөв шаардахгүй	Байршуулсан мэдээллийн тоо, хандсан иргэдийн тоо	150000	155000	Монгол Улсын стандарт “Төрийн байгууллагын вэбсайт тавих шаардлага” MNS6285: 2017 дагуу цахим хуудасны агуулга, бүтцийг тогтоон сүүлийн 5 жил шинэчлэн хөтөлж байна. Байгууллагын албан ёсны http://huemt.ub.gov.mn/ , http://www.huemn.ub.gov.mn/ цахим хуудсанд 174 мэдээ, мэдээллийг байршуулж 2025 онд 286912 хэрэглэгчийн хандалтыг авсан байна. Байгууллагын шинээр хэрэгжүүлж байгаа 10 үйл ажиллагааны талаар 10 рийлийг давхардсан тоогоор 800 зуун мянга гаруй иргэний үзэлтийг авсан.	100%
1.4.2	Гамшгийн үед иргэн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулж тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Оролцсон тусламж үйлчилгээний тоо	4	5	Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн гамшгийн эрсдлийг бууруулах, иргэн ам олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт, цар тахал болон аюулт үзэгдэлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийн гамшгийн үед үүрэг гүйцэтгэх чадварийг бэхжүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд удирдах зорилгоор эрүүл мэндийн ажилтаны орон тооны бус штабын бүрэлдхүүн, орлон ажиллах албан тушаалтанууд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай зориулалтын мэргэжлийн анги, ажиллах чиг үүргийг Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын 2025/05/27-ны өдрийн А/81 дугаар тушаалаар тодотгон батлуулсан. 2025 оны 3 сарын 25-ны *Гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх журам*-ыг хэрэгжүүлэх хүрээнд улс орон даяар газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн дадлага сургуулилтанд 14 иргэний бүрэлдхүүнтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний баг бүрдүүлж оролцсон. Дүүргийн Онцгой байдлын комиссын 2025 оны 03 сарын 14-ний өдрийн *Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай * 01 дугаар албан даалгаврын хүрээнд 2025 оны 05 сарын 05 өдөр ой хээрийн түймэрийн үеийн дадлага сургуулилтанд 10 иргэний бүрэлдхүүнтэй эмнэлгийн баг гаргаж оролцлоо. Эмнэлгийн багийн гишүүдийн хувцас хэрэгсэл, аранз, иргэнсний болон эм эмнэлгийн хэрэгсэл ороох боох материалын хангалтыг нөөцийг бүрдүүлэн ажиллав.Томуу томуу төст өвчний үеийн 2 сарын эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээг сар бүр эрүүл мэндийн газрын холбогдох хэлтэс мэдээллийн хүргүүлэн ажиллаж байна.	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1.4.3	Өсвөр үе, залуусын дунд хар тамхи, мансууруулах бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг холбогдох Ерөнхий боловсролын сургууль болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	850	1000	Электрон тамхинаас татгалзъя”, “Тамхины хор уршиг” сургалт нөлөөллийн арга хэмжээг 1 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 15 сургуулийн 4015 сурагчид хамрагдсан. https://www.facebook.com/health.promotion.center Эрүүл мэндийг дэмжих төвийн цахим хуудсанд Электрон тамхинаас сэргийлэх зөвлөмж бичлэгийг хуваалцсан. хандалтын тоо 12400	100%
1.4.4	Өсвөр үеийн охидын дунд “Жирэмслэлтээс сэргийлэх, бэлгийн замаас урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгуулна	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Сургалтын тоо, Хамрагдсан хүүхдийн тоо	1500	2000	Эрүүл мэндийн төв нь Өрхийн эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, гэр бүл төлөвлөлт”-ийн сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Сургалтад 13 сургуулийн 2778 сурагчдад хамрагдсан байна.	100%
1.4.5	Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, төлбөрийн төр даах эм олголтод хяналт хийж ажиллах	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Сэтгэц нөлөөт бодисын хор уршгыг таниулж, сэргийлсэн байдал сургалтын тоо	1	1	Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн хор уршгийн талаар сургалт сурталчилгааг Хар тамхитай тэмцэх албатай хамтран сургалтыг тогтмол хийж эмч, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдэд хамруулан ажиллаж байна. Нийт давхардсан тоогоор 560 иргэн хамрагдсан. Мөн 2025 оны 7-р сард Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газартай хамтран Мансууруулах сэтгэд нөлөөт эмийн хэрэглээ, хяналт сэдвээр эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалтыг зохион байгуулсан.	100%
1.4.6	Төвийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг ажлыг зохион байгуулах	Байгууллагын төсөв	Зөвлөлийн үйл ажиллагааны хувь	80	90	Хан-Уул эрүүл мэндийн төвийн эцэг эхийн зөвлөлийг тушаалыг шинэчлэн батлуулан үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. 2023 оны "Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам" А/240, 2024 оны "Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын 2024-2026 оны арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж 2025 оны төлөвлөгөө 3 зорилго 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийн 90% хэрэгжиж байна.	100%
1.4.7	Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалтын тоо	1	2	Эрүүл мэндийн төв нь Өрхийн эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт”-ийн сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Нийт 13 сургуулийн 2778 сурагч хамрагдсан.	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
ЗОРИЛГО-2: Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, эмч, сувилагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэн амд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хан-уул дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд							
ХОЁР: ИРГЭНИЙ НӨӨЦИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, МЭРГЭЖИЛ, МЭРГЭШЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ИРГЭН АМД ЧАНАР, ХҮРТЭЭМЖТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР “ЭРҮҮЛ ДҮҮРЭГ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД							
ЗОРИЛТ 2.1 ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫН НЭМЭГДҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД /НЗДҮАХ 2.1.5 ДАХЬ ЗААЛТ, ДЗДҮАХ-Н 2024-2028 ОН /							
2.1.1	Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн бусад албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг жилд 1 удаа зохион байгуулах, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Байгууллагын төсөв	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулагдсан ажилчдын тоо	180	200	Ажилчдын эрүүл мэнд хариуцсан эмчийг Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/184 дүгээр тушаалаар үүрэгжүүлэн ажиллуулж байна. Эрүүл мэндийн ажилтныг үзлэг шинжилгээнд хамруулах журмыг Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/75 дугаар тушаалаар баталж, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн шинээр ажилд орсон 58 албан хаагчдыг 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Заавар батлах тухай” А/537 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу үзлэг шинжилгээнд хамруулан ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын 230 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Үзлэгээр: ▪ Өндөр жингийн хэмжилт ▪ Витамин Д-ийн шинжилгээ ▪ Эрдэсийн шинжилгээ ▪ Чих хамар хоолойн эмчийн үзлэг ▪ Стрептококк илрүүлэх тест ▪ Нүдний эмчийн үзлэг ▪ Шүдний эмчийн үзлэг ▪ Зүрхний эхо ▪ Гэмтлийн эмчийн үзлэг хийгдэж, витамин Д-ийн дутагдалтай 125 хүүхдэд нөхөх тунгаар витамин Д олгож, давтан шинжилгээнд хамруулан, эрүүлжүүлэн ажилласан. 2025 оны байдлаар хамар залгиурын эрүүл зүйн шинжилгээнд 216 эмч эмнэлгийн ажилтнуудаас нийт 164 /75,9%/ эмч ,ажилчид хамрагдсаны 7,3 %-д /12/ нь эмгэг төрөгч /MRSA/ илэрсэн. Дээрх эмч ажилчдыг чих хамар хоолойн болон эмнэлгийн ажилчдын эрүүл мэнд хариуцсан эмч нарын хяналтанд авахуулж	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
						эмчилгээнд хамруулан давтан шинжилгээнд хамруулахад 1 ажилтны шинжилгээ давтан эерэг гарсан тул давтан эмчилгээнд хамруулсан. В гепатитын вакцины дараах дархлал тогтоцын шинжилгээнд хамрагдвал зохих 66 эмч, ажилчдын судалгааг гаргаж шинжилгээнд 58 эмч ажилчдыг хамруулахад 63.8% нь Anti-HBs 100mlU/ml-с дээш дархлал тогтоцтой байв. Anti-HBs 10-100mlU/ml-хүртэл дархлал тогтоцтой.-17, Anti-HBs 10mlU/ml-хүртэл дархлал тогтоцтой -4 ажилтануудыг В гепатитын эсрэг вакцины 1-3 тунд хамруулах ажлыг зохион байгууллаа. В гепатитын эсрэг дархлаажуулалтанд хамрагдах шаардлагатай 51 эмч эмнэлгийн ажилтны судалгааг гаргаж нийт 26 ажилтанг 1-3-р тунд хамруулж, В гепатитын эсрэг вакцины хамралт 85,4%-тай, улаанбурханы эсрэг вакцинд-51 эмч ажилчдыг шинээр хамруулж улаанбурханы эсрэг дархлаажуулалтын хамралтыг 97,7 %-д хүргэсэн.	
2.1.2	Эмч, ажилчдын ажиллах орчны талаар сэтгэл ханамжийн судалгаа авах, ажлын байрны таатай нөхцлийг бүрдүүлэх	Байгууллагын төсөв	Эмч, ажилчдаас сэтгэл ханамжийн хувь	70	80	Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдаас 2025 оны байдлаар сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн, гарсан санал, хүсэлтийн дагуу ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Сэтгэл ханамжийн судалгаанд 136 албан хаагч хамрагдсанаас ажилчдын сэтгэл ханамж 80.3%-тай гарсан байна.	100%
2.1.3	Эмч, эмнэлгийн мэргэжилтний багц цагийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэн ажиллах	Төсөв шаардахгүй	Багц цагийн бүрдүүлэлтийн хувь	95	98	Тус эрүүл мэндийн төвд эмчлэх эрхийн зөвшөөрлийн гэрчилгээтэй их эмч-81, бага эмч-4, эм зүйч-5, эх баригч бага эмч-4, сувилах зөвшөөрлийн эрхийн гэрчилгээтэй 42-сувилагч нийт 136 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар багц цагийн бүрдүүлэлтийг бүрэн биелүүлэн, hr.dc.gov.mn программд тухай бүр оруулан ажиллаж байна. Лицензний зөрчилтэй албан хаагч байхгүй.	100%
2.1.4	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжоор ханган ажиллах	Байгууллагын төсөв	Хуулийн дагуу ажиллаж байгаа иргэдийн тоо	15	16	Хан-Уул Эрүүл мэндийн төвд нийт 216 албан хаагч ажиллаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах ажлын хүрээнд нийт ажилчдын 8.3% буюу 18 хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдыг ажлын байраар ханган Хөдөлмөрийн тухай хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна	100%
2.1.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах дагаж гарсан дүрэм, журмын хүрээнд үйл	Байгууллагын төсөв	Архив, архив албан хэрэг хөтлөлтийн тухайн хуулийн	95	96	Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх, Цахим архив үүсгэх ажлын хүрээнд 2024 оны А тушаал-131, Б тушаал-410, нийт 541 тушаалын агуулгыг Archiv edoc системд шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Албан хэрэг хөтлөлтөд Edoc програмыг бүрэн ашиглаж хэвшсэн. 2025 оны 12 дугаар	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
	ажиллагааг зохион байгуулах, зөрчлийг бууруулах		хэрэгжилтийн хувь			сарын 03-ны өдрийн байдлаар нийт ирсэн бичиг-732, шийдвэрлэсэн-719, судалж байгаа-13 Явсан бичиг-735 байна. Ирсэн бичгийг шийдвэрлэх явцад хугацаа хэтрүүлсэн болон зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно. Хан-Уул эрүүл мэндийн төвийн дэргэдэх Баримт нягтлан шалгах комисс 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хуралдан, 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулж, байгууллагын архивыг нөхөн бүрдүүлэх талаарх үйл ажиллагааг хэлэлцсэн. Архивт баримт хүлээн авах хуваарь гарган, хуваарийн дагуу 2025 оны 01 дүгээр улиралд багтаан алба тасгуудаас баримтуудыг архивт хүлээн авч, Архивын ерөнхий газрын даргын 2023 оны “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” тушаалын дагуу Архивт хүлээн авсан баримтуудыг нэр төрөл, хадгалах хугацаагаар нь (байнга, түр, 70 жил) ангилан төрөлжүүлж, зохих журмын дагуу үдэж хавтаслан хадгаламжийн нэгж бүрдүүлэн Байнга хадгалах-25, Түр хадгалах-165, 70 жил хадгалах-3, нийт 193 хадгаламжийн нэгжээр байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Монгол улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэл ажлыг ханган, 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр архивын үзлэгт амжилттай хамрагдсан. Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах ажлын хүрээнд: 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан хэрэг хөтлөлтөд монгол бичгээр хослон хөтлөх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
2.1.6	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа багасгах, зөрчлийн тоог бууруулж ажиллах	Төсөв шаардахгүй	Шийдвэрлэлтийн дундаж хоног	5	4	Төрийн албаны нэгдсэн систем Ер.ulaanbaatar.mn систем болон иргэнээс амаар болон бичгээр ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар гомдол, санал, хүсэлт, талархлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гомдол 13%-иар буурсан үзүүлэлттэй байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 9 цагтай. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Шийдвэрлэлтийн дундаж хувь 99% Зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй. Өргөдлийн хаалтыг хууль эрх зүйн үндэслэлтэй хааж иргэн болон хуулийн этгээдээс өргөдөл гомдол гаргахгүй байх талаар анхаарч ажиллаж байна. Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
						гарган Нийслэлийн эрүүл мэндийн газар, Дүүргийн засаг даргын тамгын газарт хуваарийн дагуу тайлагнаж ажилласан.	
2.1.7	Эмнэлзүйн ур чадварыг хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж сургалтын хэрэгсэлтэй болгох	20	Сургалтын хэрэгсэлийн тоо	2	3	Эмнэлзүйн ур чадварыг хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж сургалтын хэрэгсэлтэй болгох ажлын хүрээнд Уян зүүний багц-1-15 сувилагч	100%
			Хамрагдсан ажилчдын тоо	80	90	Асаргааны багц-1/ 5 туслах сувилагч Холголт цооролтын баг-1/ 6 сувилагч Хэл ярианы болон сул хараатай сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах багц-1/20 сувилагч хамрагдсан байна. Нийт-4 багцыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн тухайн үйл ажиллагаанд 120 гаруй ажилчид хамрагдсан байна.	
2.1.8	Шинээр ажилд орсон сувилагч нарыг шинэ сувилагчийн хөтөлбөрт хамруулах	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Шинээр ажилд орсон сувилагчаас сургалтад хамрагдсан хувь	60	75	Шинээр ажилд орсон сувилагч нарыг шинэ сувилагчийн хөтөлбөрт хамруулан ажиллаж байна. 1. ЭМТ-өөс чиглүүлэх сургалт-2 удаа 2. Ёс зүйн хорооноос зохион байгуулсан – Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй сэдэвт сургалт-7/100% 3. ОУ – ын Сувилагч нарын өдрийг тохиолдуулан Япон сувилагчтай хамтран *Ахмад насны асаргаа* сэдэвт сургалт4/80% 4. Халдвар судлаач *Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгаалал мөрдөх дүрэм* сэдэвт сургалт 5/100% 5. ЭЭЯТТ – ийн ахлах сувилагч О.Дорж – ЭМС – ын А/406 дугаар тушаал, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн дүрэм сэдэвт сургалт 5/100% 6. ХЭТ – ийн ахлах сувилагч С.Оюунбилэг *Үйлчлүүлэгч тээвэрлэх журам* сэдэвт сургалтанд тус тус хамрагдсан 5/100% Таагүй ба ноцтой тохиолдлын тоо-0	100%
			Шинэ сувилагчаас үзүүлсэн тусламж, үйлчилгээтэй холбоотой таагүй ба ноцтой тохиолдлын тоо	0	0		
2.1.9	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Байгууллагын төсөв	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	92%	95%	Эрүүл мэндийн төвөөс Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээний төлөвлөгөөг Төвийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хан-Уул Эрүүл мэндийн төвийн Байгууллагын дотоод журам, Үйлдвэрчний эвлэлийн Хамтын гэрээнд заасны дагуу ■ Цалингийн урамшуулал 103 албан хаагчдад 114,500,000 төгрөг	98%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
						- Мөнгөн тусламж 8 албан хаагчдад 3,200,000 төгрөг - Сургалтын цалинтай чөлөө 12 албан хаагчдад 46,200,000 төгрөг - Эрүүл мэндийн төвийн нийтлэг үйлчилгээ болон угтах үйлчилгээний 21 албан хаагчдад 5,795,200 төгрөгний ажлын хувцас, хэрэглэл - Ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нян судлалын лаборатори, диализ, серверийн өрөөнүүдэд 17,800,000 төгрөгний өртөг бүхий 4 кондейшныг байршуулан, нийт 187,495,200 төгрөгний урамшуулал олгоод байна. Албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор тамифлюг 75мг нийт албан хаагч нарт мөн артерын даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлж каптоприл 25мг №30 212 ширхэгийг, томуу, томуу төст өвчнөөс сэргийлж нийт албан хаагчдын хүүхдүүдэд ТУССЕФИН бэби сироп болон Д витаминь 300 гаруй хүүхдүүдэд өгсөн, витамин С г нийт 215 албан хаагчдад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 удаа тараасан. 2025 оны байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 94.5 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	
2.1.10	Эрүүл мэндийн мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албыг орон тоогоор тогтвортой ажиллуулах,	Байгууллагын төсөв	Чанарын албаны албан тушаалтны чанарын албанд ажилласан дундаж сар	12	24	Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Бүтэц орон тоо батлах тухай” А/01 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанар аюулгүй байдлын албыг - Чанарын албаны дарга - Чанарын менежер - Эрсдлийн менежер - Лавлагаа мэдээллийн ажилтан зэрэг 4 орон тоотойгоор баталсан 2025онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанар чюулгүй байдлын алба нь чанарын албаны дарга, чанарын менежер, эрсдлийн менежер гэсэн 3 орон тоогоор ажиллаж байна. Ажилласан хугацаа: - Чанарын албаны дарга 5 жил - Чанарын менежер-8 жил - Эрсдлийн менежер -10 сар Дундажаар ажилласан сар-53 сар байна	100%
2.1.11	Эрүүл мэндийн ажилчдын Нийгмийн баталгааг хангах		Орон сууцжуулах	0	2	Эрүүл мэндийн ажилчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдаас орон сууцны ипотекийн	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
	хөтөлбөрийн хүрээнд орон сууцжуулах хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Байгууллагын төсөв	хөтөлбөрт хамрагдсан ажилчдын тоо			зээлийн дэлгэрэнгүй судалгааг авч ажилласан. Нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 71.1% нь ипотекийн зээлтэй, үлдсэн 28.3% нь хамрагдаагүй гэсэн судалгаа гарсан байна. 2025 онд ипотекийн зээлд 3 ажилтныг хамруулсан байна. Цаашид ажилчдыг ипотекийн зээлд хамруулах оочер, дугааргүй хамруулах талаар Худалдаа хөгжлийн банктай зөвшилцөж байна.	
2.1.12	Ахмад настныг хөдөлмөр эрхлэх боломжоор ханган ажиллах, нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг ажиллуулах	Байгууллагын төсөв	Ажиллаж байгаа ахмад настаны тоо	15	16	Эрүүл мэндийн төв нь нийт 216 албан хаагчид ажиллаж байгаагаас 31 албан хаагч нь тэтгэвэртээ гараад ажиллаж байгаа ахмад настан байна. Энэ нь нийт ажилчдын 14.3%-ийг эзэлж байна.	100%
2.1.13	Ахмад настаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ахмад настны үзлэг, оношилгоог зохион байгуулах	Улс, нийслэл, дүүргийн төсөв,	Эрсдэлт бүлгийн ахмад настанг хамруулсан тоо	65	150	Улсын нэгдүгээр төв эмнэлэг болон бусад эмнэлэгүүдтэй хамтран Ахмад настаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ахмад настны үзлэг, оношилгоог зохион байгуулах ажлын хүрээнд 2025 оны байдлаар 878 ахмад настанг 14 төрлийн эмч нарийн үзлэг, шинжилгээнд хамруулсан.	100%
			Хамрагдсан ахмад настны тоо	200	600		
2.1.14	Бага насны хүүхдүүдэд мэдрэлийн эмчийн үзлэгийг хийх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх	Байгууллагын төсөв	Мэдрэлийн эмчийн тоо, үзүүлсэн хүүхдийн тоо	0	150	Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Б/191 дүгээр тушаалаар мэдрэлийн эмчийн орон тоог нэгээр нэмэгдүүлэн, бага насны хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	100%
2.1.15	Хүүхдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтний мэдлэг ур чадварыг үнэлэх, дадлагажуулах сургалт зохион байгуулах	Байгууллагын төсөв	Үнэлгээнд хамрагдсан ЭЭМТ-ийн тоо	20	21	Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламжийн сургалтийг ЭМТҮЧАБА-ы дарга, АУ-ны магистр, Клиникийн профессор, Зөвлөх зэргийн эмч А.Оюунчимэгийг урин 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Хан-Уул ЭМТ-н 308 дугаар өрөөнд 21 ЭЭМТ-н хүүхдийн асуудал хариуцсан эмч нарыг оролцуулж, сургалт дадлагыг зохион байгуулсан. хамрагдсан эмчийн тоо - 25 Дадлагжуулах сургалтанд хамрагдсан эмчийн тоо - 10	98%
			Хамрагдсан эмчийн тоо	11	15		
			Дадлагажуулах сургалтад хамрагдсан эмч нарын тоо	5	8		
2.1.16	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний шилдэг сувилагч шалгаруулах арга	Байгууллагын төсөв	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний	0	1	Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Бүтэц орон тоо батлах тухай” А/01 дүгээр тушаалаар хөнгөвчлөх эмчилгээний сувилагч 1 орон тоогоор батлагдсан.	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
	хэмжээг зохион байгуулах, сургалтад хамруулах, мэргэшсэн иргэний нөөцөөр хангах		сургалтад хамрагдсан эмч, сувилагчийн тоо, хувь			Тушаалын дагуу хөнгөвчлөх хими эмчилгээгээр мэргэшсэн сувилагч ажиллаж байна.	
2.1.17	Эм зүйчдийг клиник эм зүйчийн мэргэшүүлэх сургалтад хамруулах	Байгууллагын төсөв	Мэргэшсэн клиник эмч зүйчийн тоо	2	3	Эм зүйн алба нь эм зүйн албаны дарга, клиник эм зүйч-2, нөөц хариуцсан эм зүйч, химийн эм найруулагч гэсэн 5 орон тоогоор ажиллаж байгаа бөгөөд бүгд клиник эм зүйчийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан.	100%
2.1.18	Төрийн албан хэргийг 2025 оноос кирилл болон монгол бичгээр хослуулан хөтлөх ажлын хүрээнд төвийн ажилчдыг чадавхжуулах, анхан болон дунд шатны сургалтыг зохион байгуулах	1.5	Сургалтад хамрагдсан ажилчдын тоо	0	80	2025 оны 04 сарын 14 өдөр “Төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах тухай” А/53 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар сургалтын төлөвлөгөөнд эмнэлгийн мэргэжилтнүүдэд монгол бичгийн албан хөтлөлт түүнийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган эхний байдлаар судалгаа авч сургалтын гарааны үнэлгээ хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна. Кирилл болон монгол бичгийн судалгааг нийт 113 албан хаагч оролцсоноос маш сайн 12 сайн 30 дунд зэрэг 50, огт мэдэхгүй 21 албан хаагчийн судалгаа гарсан. Судалгаанд тулгуурлан огт мэдэхгүй 21, дунд зэрэг 50 ажилтныг 2 хуваан 2025 оны 06 дугаар сарын 06-ний өдөр анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Албан хэрэг хөтлөлтийг 2025 оны 04 сарын 01-ны өдрөөс монгол бичгээр хосолсон хөтөлж эхлэсэн. Төрийн албан хэргийг 2025 оноос кирилл болон монгол бичгээр хослуулан хөтлөх ажлын хүрээнд 95 албан хаагчийг сургалтад хамруулсан.	100%
2.1.19	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах АЗ сертификатын суурь мэдлэг олгох сургалтад хамрагдан, гэрчилгээг авах	Байгууллагын төсөв	Сургалтад хамрагдсан ажилчдын тоо	4	9	Хан-Уул Эрүүл мэндийн төв нь 2025 оны 1-р сард нийт 12 эмч, эмнэлгийн ажилтанг төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах АЗ сертификатын суурь мэдлэг олгох сургалтанд хамруулсанаас 1 эмч тэнцэж, 3-р сард мөн 11 эмч, эмнэлгийн ажилтанг хамруулж 1 эм зүйч тэнцэж, сертификатаа авсан. Байгууллагын зүгээс АЗ сертификаттай нийт 10 эмч, эмнэлгийн ажилтан байна.	100%
ЗОРИЛТ 2.2 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД							
2.2.1	Дээд байгууллагаас ирсэн захирамж, тушаал, шийдвэр, журам, дүрмийг цахим хуудас болон вэб	Төсөв шаардахгүй	Захирамж, тушаал, шийдвэр, журмын тоо	15	18	2025 оны байдлаар Эрүүл мэндийн төвд дээд газраас ирсэн тушаал, захирамж, албан даалгавар, зөвлөмж нийт 57 албан бичиг ирсэн бөгөөд тухай бүр биелэлтийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
	сайтад байршуулан ажилтнууддаа танилцуулж ,хэрэгжилтийг хангаж ажиллах					Эрүүл мэндийн сайдын албан даалгавар-3 Эрүүл мэндийн сайдын тушаал-8 Нийслэлийн засаг даргын тамгын газрын улсын байцаагчийн зөвлөмж-1 Нийслэлийн засаг даргын захирамж-8 Нийслэлийн эрүүл мэндийн газрын албан даалгавар-1 Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал-17 Хан-Уул дүүргийн засаг даргын захирамж-16 Хан-Уул дүүргийн онцгой комиссын тушаал, албан даалгавар-3 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зөвлөмж-1 тус тус ирсэн байна. Дээд шатны байгууллагуудаас ирсэн тушаал шийдвэрийг тухай бүр алба нэгжийн дарга нар болон эмч, сувилагч нарын яриан дээр танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
2.2.2	Нээлттэй ажлын байрны зарыг хөдөлмөр зуучлалын байгууллагууд болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, цахим хуудсанд байршуулна.	Төсөв шаардахгүй	Ажлын байрны зарыг мэдээлсэн тоо	14	16	Иргэний нөөцийн ил тод байдлын хүрээнд сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна. Байгууллагын болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, цахим хуудсанд 2025 оны жилийн эцсийн байдлаар ажлын байрны зарыг 36 удаа байршуулсан.	100%
2.2.3	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эко киоск, E-Mongolia систем ашиглан үйлчилгээг цахимжуулах ажлыг өргөжүүлэх	Төсөв шаардахгүй	Үйлчилгээг авсан иргэдийн тоо	15600	16000	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эко киоск, E-Mongolia системээс үзлэгийн цаг товлосон 25568 иргэн, Эко киоск төхөөрөмжөөс 20027 иргэн шинжилгээ хариу хэвлэж авсан байна.	100%
2.2.4	Монгол Улсын засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмын хэрэгжилтийг ханган ажиллах	Төсөв шаардахгүй	Мэдээллийн аюулгүй байдлын журамтай байна.	0	1	Кибер аюулгүй байдлын тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 224 тогтоолоор баталсан кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг шинэчлэн батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
2.2.5	Нийслэл, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад дээд	Төсөв шаардахгүй	Төлөвлөгөө, тайлан, биелэлтийг тухай бүр	100	100	Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, тайлан болон бодлогын баримт бичгийн тайлан, биелэлтийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
	шатны байгууллагуудад төлөвлөгөө, тайлан, тогтоол шийдвэрийн биелэлтийг тухай бүр гаргах, хэрэгжилтийг ханган ажиллах		гаргасан, биелэлтийн хувь			хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан холбогдох зорилт, арга хэмжээний биелэлтийн хүрээнд Нийслэл, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад дээд шатны байгууллагын холбогдох хэлтэс, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.	
ЗОРИЛГО-3: Иргэн амд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, тусламж үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд							
ЗОРИЛТ 3.1 ИРГЭДЭД ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ /МУЗГ- 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.4 ДЭХ ЗААЛТ, НЗДҮАХ-2.1 ДЭХ ХЭСЭГ, ДЗДҮАХ-Н 2024-2028 ОН/							
3.1.1	Эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч жирэмсэн үеийн ургийн гажгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай TORCH халдварыг илрүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, хэрэгжүүлнэ.	Улс, нийслэл, дүүргийн төсөв	/TORCH/ шинжилгээний аппаратын тоо,	0	1	Эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч жирэмсэн үеийн ургийн гажгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай TORCH халдварыг илрүүлэгт 2025 оны байдлаар өсөлтгүй жирэмсэн 30 бүртгэгдсэн бөгөөд онош тодруулах зорилгоор 3 дахь шатлалын эмнэлэг руу илгээхэд 18 эмэгтэйн TORCH шинжилгээ өөрчлөлтэй гарсан тул эмчилгээнд хамруулан эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд байна.	100%
3.1.2	9,18,36 сартай хүүхдүүдийн өсөлт, хөгжилтийн хоцрогдолыг эрт илрүүлэх цогц үзлэгт сар бүр хамруулж үр дүнг тооцон ажиллах	Улс, нийслэл, дүүргийн төсөв	Өсөлт хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэлтийн хувь	95	96	9,18,36 сартай хүүхдүүдийн өсөлт, хөгжилтийн хоцрогдолыг эрт илрүүлэх цогц үзлэгт сар бүр хамруулж үр дүнг тооцон ажиллаж байна. 2025 оны байдлаар нийт 2142 хүүхэд хамрагдвал зохиоос 2086 буюу 98 хувийг хамруулсан. Үүнээс хөгжлийн хоцрогдол илэрсэн хүүхэд байхгүй байна. Мөн хүүхдийн гэрийн эргэлт, эргэн мэдээлэл болон хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхэд хариуцсан эмч нарт танхимаар болон цахимаар сургалтыг зохион байгуулсан.	100%
3.1.3	“Сайн туршлага-2025” шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна. Эмнэл зүйн сайн туршлагыг бүртгэн мэдээлэх, сурталчлах ажлыг өрнүүлэх	0,75	“Сайн туршлага арга” хэмжээнд оролцсон бүтээлийн тоо	10	11	2025 онд Нийслэлийн Эрүүл мэндийн газраас зохин байгуулсан “Сайн туршлага “арга хэмжээнд -Эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөвчлөх хүртээмж сайжруулах номинаци-3 -Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологи номинаци -3 -Шинээр нэвтрүүлсэн оношлогооны технологи номинаци -3 -Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах номинаци-2 Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ-1 -Нийгмийн эрүүл мэнд - номинаци -3 - нийт 15 бүтээлээр оролцсон.	100%

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
						Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах номинацид Хан-Уул Эрүүл мэндийн төвийн “NuPort-CT (Венийн портын систем) болон порт зүүг эмчилгээнд ашиглах нь” Тэргүүн байр эзэлж, Манал Үйлс ӨЭМТ -Ясны нягтаршил хэмжих хэт авиан оношилгоо -шилдэг бүтээлийн гэрчилгээ авсан, Мөн оролцсон 15 бүтээл нь батламж авсан.	
